

Бөөсөнд нуугдсан бизнес

Монголд толгойн бөөсний халдвар ихсэж тэр тусмаа цэцэрлэг болон баг ангийн сурагчид, эцэг эхчүүд, багш нарын толгойн өвчин болжээ. Нэрэлхүү зантай монголчууд энэ асуудлыг эл гаргаж тавих хүсэлгүй, далдхан шийдэх арга зам хайсаар л. Гэртээ хүүхдийнхээ үсийг угаагаад, шүүрдэж самнаад ч шийдэж чадахгүй эцэг эхчүүд эцсийн арга бөөсний салон болж байна гэдгийг бидэнтэй уулзсан ээжүүдийн яриа гэрчилж байна. “Бөөсний салон” нийслэлийн хэд хэдэн хэсэгт үүд хаалгаа нээн, бөөстэй тэмцэж эхэлжээ. Үүний нэг Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Хурд Рапид” хотхонд байрлах бөөсний салоныг зорилго. Эдийн засагч мэргэжилтэй Г.Ганбилэг нь “Lice cleaning салон” нэртэй тус салоныг үүсгэн байгуулаад гурван сарын нүүр үзэж байгаа аж. Энэ хугацаанд 300 гаруй үйлчлүүлэгч зорин иржээ. Дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй тэд ачааллаа дийлэхгүй өдрүүд цөөнгүй байдаг тухай ярьж байлаа. Нэг удаагийн үйлчилгээ авахад 80 мянган төгрөг бөгөөд бөөстөлтөөс шалтгаалан хэдэн ч удаа ирэх тохиолдол байдаг байна. Харин багцын үйлчилгээ 180-220 мянга төгрөгийн үнэтэй.

Бөөсний тархалт халдварын тухай “Арьсны өвчин судлалын үндэсний төв”-ийн Хүүхдийн тасгийн эрхлэгч эмч Д.Уранцэцэг

“ ” Арьс өвчин судлалын амбулатори дээр бөөснөөс үүдэн эмгэгшсэн иргэн цөөнгүй ирж байна. Тухайлбал, цэцэрлэгийн насныхан дийлэнх хувийг эзэлж буй юм. Энэ нь цэцэрлэг сургуулийн нягтаршил их, дүүргэлт хэтэрсэнтэй шууд холбоотой байна. Эмнэлэг эрүүл мэндийн байгууллагын зүгээс бөөсийг хэвтүүлэн эмчлэх боломжгүй. Ор тасалгаа болон эмнэлгийн даац хүрэлцэхгүй. Тиймээс мэргэжлийн үүднээс зөвлөгөө өгч гэрийн нөхцөлд арилгах чиглэл өгдөг. Нийгэмд бөөс нь бохир заваанаас үүсдэг гэх ташаа ойлголт байдаг. Энэ бол худал зүйл, ямар ч давхаргын хүмүүс өвчлөх боломжтой халдварладаг өвчин. Учруулах хор хөнөөлийн хувьд тууралт гарч загатнах, хазсан шарх нь загатнах, хуйханд хөндүүр шарх үүсэх, шөнө унтахад тухгүй болох зэрэг сөрөг нөлөө илэрдэг. Цэвэрлэж устгахгүй удвал арьсанд гүн шигдэж цаашлаад цусанд үрэвсэл үүсгэх эрсдэлтэй байдаг” гэдэг мэдээллийг өгсөн.

Бөөсийг бохир заваан зүйлээс үүддэг, нийгмийн эмзэг давхаргынхан л өртдөг гэх буруу ойлголт, мэдээлэл дутмаг байдал нь энэ халдвар хурдацтай тархахад нөлөөлдөг аж. Бусдад ярихдаа ичих, санаа зовох, манай хүүхдийг “бөөстэй” хэмээн гадуурхах вий зэрэг айдсаас үүдэн энэ халдварыг даамжрахад хүргэдэг гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна. Энэ буруу ташаа ойлголтоос үүдэн монголчууд тэр чигтээ толгойн бөөстэй болохыг ч үгүйсгэх арга алга. Бөөс нь хүний цусаар хооллодог шимэгч амьтан. Дэлхийн бүх оронд тархсан халдварт өвчин аж. Жилд 100-аас дээш сая хүн өвчилдөг гэсэн баримт ч хүртэл байна. Тэр битгий хэл “Дэлхийн бөөсний өдөр” байдаг. Жил бүрийн 10 дугаар сарын 12-нд бөөснөөс үүсэх эрүүл мэндийн асуудлуудыг ойлгуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих зорилготой аж. Үүнээс харахад олон улсад аль хэдийн бөөсний халдварыг хүлээн зөвшөөрчээ. Тухайлбал АНУ-д жилд 12 сая хүн бөөсний халдвараар өвчилдөг. Бусад хүн амын нягтаршил ихтэй БНХАУ, Энэтхэг зэрэг улсад бөөсний клиник эмнэлэг хүртэл нээгдсэн байдаг гэнэ. Тиймээс бид бөөсийг заваан, нийгмийн доод давхаргынхан өвчилдөг, ядуусын зэрэг үзлээ эцэслэх цаг иржээ.

Бөөс нь толгойн, биеийн, бэлгийн бөөс гэх гурван төрөл байдаг. Манай улсын хувьд 90 хувь нь толгойн бөөс байна гэж мэргэжилтэн хэлэв. Мөн хоёр хүйсээр ялгадаг эм нь нэг сар амьдарч өдөр бүр 7-10 өндөг гаргах чадвартай. Өндөгний боловсрох хугацаа нь найман долоо хоноод хуурс болно. Хуурс нь ахин найман долоо хоноод бөөс болох процессоор үржин ихэсдэг. Цагаан өнгөтэй нүдэнд амархан анзаарагдах боломжтой. Зарим асран

хамгаалагчдын хувьд мэдэхгүйн улмаас үүдэн хуурсыг үсний хагтай андууран тоолгүй орхисноос бөөстөлт улам нэмэгдэх, цааш халдварлах нөхцөл үүсдэг гэдгийг ярилаа.

“Live cleaning” салонд бөөсний тухай мэдлэг мэдээлэл дутмаг эцэг эхчүүд их ирдэг байна. Ихэвчлэн “манай хүүхдийн толгойд харшил өгч тууралт үүссэн” гэж хандах нь элбэг гэнэ. Салоны үйлчлүүлэгчийн олонх нь цэцэрлэгийн насныхан. Мөн хүүхдээсээ бөөсний халдвар авсан ээжүүд ч цөөнгүй гэлээ.

Бөөсний өөр нэг бизнес үүсэж бүр луйврын шинжтэйгээр цэцэглэж байна. Энэ бол цахим орчинд зарагдаж буй “бөөсний шампунь” гэх хулхи бараа бүтээгдэхүүн гэдгийг зарим эх сурвалж хэлж байна. Тухайн шампунь химийн орц найрлага ихтэй учир үсний хуйхыг түлж харшил үүсгэдэг гэж хэрэглэж үзсэн ээжүүд ярьж байв.

“Lice cleaning” салоныхон химийн найрлагатай бүтээгдэхүүн аль болох баг ашиглаж тэрчлэн гар аргаар түлхүү цэвэрлэдэг гэж ярьж байна. Бөөсний өвчлөлийн 80 хувийг цэцэрлэгийн насныхан болон бага ангийнхан эзэлж буй тухай мэргэжилтнүүд хэлж байв. Нийслэлийн 243 дугаар цэцэрлэгийн эмч М.Жаргалтуяа

“Цэцэрлэгийн насныханд бөөсний халдвар их байна. Бид өдөр тутамдаа үзлэг хийдэг. Үзлэгээр бөөс илэрвэл эцэг эх, асран хамгаалагчид нь мэдэгдэж бөөсийг нь бүрэн цэвэрлэж дууссаны дараа цэцэрлэгт хамруулахыг шаарддаг. Асран хамгаалагчид өөрсдийн ажлаас үүдэн хүүхдээ цэцэрлэгт нь тогтмол явуулахыг хүсдэг. Энэ нь бусад хүүхдэд бөөсний халдвар халдах эрсдэлтэй байдаг” гэж ярьсан.

Бөөс нь хоорондоо хүрэлцэх, сам болон боолтоор халдварлан дамждаг. Нэг ангид байх хүүхдийн тоо хоёр, гурав дахин хэтэрсэн нь бөөсний халдвар хурдацтай тархахад нөлөөлж байгааг цэцэрлэгийн багш Н.Нарангэрэл хэлэв. Нийгмийн халдварт өвчнөөс салахын тулд нийтээрээ, үнэн зөв мэдээлэлтэй байх нь чухал байна. Толгойн бөөс нэг хэсэг хүмүүсийн нөгөө хэсгийнх нь бизнес болоод амжлаа. Мэргэжилтнүүдийн яриа бодит байдлаас харахад энэ асуудлын гол шалтгаан нь эргээд л нийгмийн хүнд асуудал болоод ирж байна.

Гарч шийдэл хайдаг ч шийдэж чадахгүй байгаа. Өөрөө хэлбэл бас нэгэн шийдэлгүй асуудал үүслээ.

Хэдэн жилийн өмнө Хятад улсаас орж ирсэн үсний боолтоос бөөс гарсан гэх мэдээлэл тархаж нэг хэсэг хүн итгэж ч байв. Энэ нь шинжлэх ухааны үндэслэлгүй зүйл болохыг эрдэмтэд хэлдэг. Өнөө цагт хамгийн чухал нь нийтээрээ үнэн зөв мэдээлэл, ойлголттой байж, бөөсийг хүлээн зөвшөөрөх зайлшгүй шаардлага үүсжээ. Бөөс аль хэдийн нийгмийн эрүүл мэндийн нийтээрээ анхаарах ёстой асуудал болсныг мэргэжилтнүүд батлан хэлж хүлээн зөвшөөрч байна.

Бөөс бизнес болсон шалтгаан нь “ядуусын өвчин”-өөр халдварлаж нийтийн дунд гадуурхагдах байх, доромжлогдох вий гэсэн сэтгэл зүйн айдсаас үүдэлтэй. Нэрэлхэж нуугдах бус нийтээрээ бөөсийг хүлээн зөвшөөрч, далд биш эл тэмцэх цаг болсон.

Баацагааны “банхар” Пүүжээ

Гуравхан хоногтой нярай амьдралын хувь төөргөөр элбэрэлт ээж, ачлалт аавдаа ирсэн түүх. Хөгшин шарга ингэндээ хоёр арга тэгнээд нөхөртөө “аргал түүгээд ирье” гэхээд гарсан Лэгжмаа өлгийтэй хүүхэд тэвэрсээр буусан өвлийн нэгэн орой. Хөх толгойд өвөлжиж байсан Пүрэвжавынх бүл нэмж баяр гийсэн өдөр. Лэгжмаа бүсгүй нутгийн сайхан хөгшин Зандарьяа гуайнхаас, дотно нөхөр Баясгалангийнхаа хүүг өргөж аваад харьж ирэн буй нь энэ. Чойсүрэн гялхайгаас хүүдээ нэр хүртэл аваад, ламтанд барих хадгийг хүүгийн өвөө Зандарьяа гуай өгч явуулсан, хүүгийн нэр өөрийнхтэй нь онож таарсан зэрэг өдөржин өрнөсөн аз жаргалтай үлгэр мэт үйл явдал. Аргал түүхээр явсан ч хоосон аргаа савлуулан, нэгэн зүйл тэвэрсээр үдшийн цагаан гэгээнээр жонжуулсаар ирж буй эхнэрээ харуулдан гадна зогсох Пүрэвжав хэрхэн гадарлах билээ. Тиймдээ ч уяа руу очихдоо “Наадах чинь юу вэ?” гэж асуусан байлгүй. Гэхдээ “Хүү, чи бид хоёрын хүү” гэдэг нэхийн дотроос дөнгөж цухуйх хариулт л түүнд хангалттай байжээ. Өлгийтэй нялх амьтныг итгэж ядан өргөөд улайн царайг нь үнэрлэхдээ үг дуугүй гэр рүүгээ алхчихсан гэдэг. Энэ үед Лэгжмаагийн дотор Баясгалангийнх нь “Хүүгээ найздаа өгнө өө” гэж хэлсэн амлалт, “Саяхан хөхсөн юм, одоо унтаж байна” гээд авчирч тэврүүлсэн дүр төрх, нялх биетэй эхийн туяа татсан дулаан инээмсэглэл бодогдож, хэдхэн сарын өмнө хорвоод эцэг эхдээ мэндэлж чадахгүй явсан үр нь эргээд ирэх шиг санагдаж уярч нялхарсан бодолд хөтлөгдсөөр гэртээ оржээ. Хэзээ, хэрхэн хадгалсныг үл санах үхрийн эвэр “Хүүдээ угж хий” гэсэн мэт гэрт нь байна. Ямааны бүлээн сүүг бувалзтал хөхөх бяцхан улаан хүү. Ингэж тэр

Алган дээрээ бөмбөрүүлсэн

Айлын хооронд үүрсэн

Азай буурал ижийдээ ирсэн юм.

Чойсүрэн гялхайн судар сөхөж өгсөн, эцэг Пүрэвсүрэнгийн гурвантаа шивнэж хайрласан нэрийн өмнө Монгол улсын Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн зохиолч яруу найрагч хэмээх алдар цолыг нэмж, түмэн олны их хайр хүндлэлийг араас нь дагуулсан юм.

Эгэл амьдралын он жилүүдээ ээж аавын хайр ачлалыг бүтээл туурвилдаа мөнхөлж, монголын утга зохиолд уянгын шан татаж намтар түүхээ мөнхлөн үлдээснийг уншигчид та бүхэн мэдэх учиртай. Зургаан настайгаасаа хонь мал эргүүлж тусад орсон П.Пүрэвсүрэн, 14 настай аав ээжээсээ холдон эрдмийн мөр хөөсөн гэдэг.

Дэрсэн далай нутгаасаа дэлэм тохой ч холдож үзээгүй тэр. Хэрсэнгийн их талаар тэмээний эрэлд мордсон аавынхаа эзгүйд үеийн нөхөр н.Рагчаатайгаа аймгийн төвийг зорьжээ. Шуудангийн машины тэвш дээр суугаад хөдлөхөд сумын захиргааны үүдэнд хүмүүсийн дунд бөөвийн зогсоод бөмбөрөх нулимсаа ханцуйгаараа арчих ижийгээ өөрийн эрхгүй өрөвдөж хоолой арган нулимс унагасан тухайгаа П.Пүрэвсүрэн зохиолч “Өдрийн сонинд” нэгэн ярилцлагадаа дурдсан байдаг. Баянхонгор аймгийн төвөөс Баацагаан сум 235 километр. Гэвч энэ зай хүүгээ санасан ижийн сэтгэлд ойрхон байсан юм. Лэгжмаа гуай намрын сэрүүн, өвлийн хүйтэнд шуудангийн задгай тэрэгний тэвшин дээр сэгсчүүлэн аймгийн төвд суугаа хүү рүүгээ тэмүүлсээр ирдэг байжээ. Тэгээд удаа ч үгүй ижий аав хоёр нь аймаг нүүж, их сургуульд оюутан болоход нь дагаад хотод ирж, хонгор нутгийн хоёр хотын айл болсон түүхтэй.

Баацагааны төвөөс эхэлж эрдэм номын мөр хөөж “Горькийн-нэрэмжит утга зохиолын сургууль” хүртэл үргэлжлэв. Сурсан мэдлэг, утга уянга, авьяас чадвараараа монголын уран зохиолд, зохиолч нөхдөдөө ихэд хүндлэл хүлээсэн нэгэн байв. Түүнд хүн бүхэн хайртай. Атаа хорсол огт үгүй, сэтгэлийн туяа бусдыг алгасалгүй түгдэг ажээ. Найз нөхөд, уран зохиолын хүрээнийхэн түүнийг “банхар пүүжээ” гэнэ. Түүний туйлын дотно, үнэнч, анд нөхөрлөлийн үнэ цэн хүнлэг журамт сэтгэлийг нь ийнхүү зүйрлэн авгайлжээ.

П.Пүрэвсүрэн найрагч олонтойгоо явсан хүн. Тэрээр хуучнаар Багшийн дээдийн газарзүйн ангийн оюутан байхдаа, зохиолч Ш.Сүрэнжавтай танилцаж, улмаар утга зохиолын дугуйланд элсэн орсноор их утга зохиол гэх айлд эргэлт буцалтгүй урважээ. П.Бадарч, Ш.Сүрэнжав, П.Пүрэвсүрэн гурвыг “шадар гурав” хэмээн хочилдог байж. Хожмоо тэд бүгд Төрийн шагнал хүртэж өөр өөрсдийн уран бүтээлийг үе үеийн уншигчдын зүрх, оюун сэтгэлд мөнхлөн үлдээсэн билээ. Тэдний нөхөрлөл одоо ч дуусаагүй. Түүнтэй уулзсан хүн бүхэн түүний сайхан энерги, хүний хайлан болсон сэтгэлийг гайхан шагширдаг хэмээн зохиолчийн анд нөхөр П.Бадарч түүнийгээ үгүйлэн санаж сууна.

“Хүн байгалийн харилцан хамаарлын хам шинж болоод утга уянга түүний уран бүтээлээс нэвт мэдрэгддэг. “Нас бол нас”, “Шувууны хараал”, “Өшөө” гэсэн өгүүллэгүүд түүнд бий. Хүн ерөөсөө хүн биш болсон тухай зохиолууд нь өгүүлдэг. Өс хонзон, үйлийн үрийн тухай гэхээсээ хүн өөрөөсөө өс авч, өөрийгөө үгүй хийж байдгийг бичсэн гэж боддог. Чухамдаа биднийг хэн ч биш бид л өөрсдийгөө үгүй хийж байдгийг түүний өгүүллэгүүд хэлээд л байдаг” хэмээн утга зохиол судлаач, доктор агсан П.Батхуяг нэгэнтээ бичсэн нь бий.

Хүмүүний нэг нас дуусавч, түүний үр хүүхэд, дурсамж хэдэн зуунд ч амьдарсаар байдаг. Ийм л жишгээр зохиолчийн “Их тээлийн даваа” туужийг 44 жилийн дараа энэ оны тавдугаар сард “Nojo publishing” хэвлэн гаргасан нь өнөө үеийн уншигчдыг шимтүүлэв. 44 жилийн дараа хавтсаа сольсон ч бусад нь хэвээрээ “Их тээлийн даваа” шинэ үеийн уншигчдын зүрхэнд хүрч, түүнийг ямархан зохиолч, ямар хүмүүн явсныг сануулахын сацуу утга уянгын туужууд үгүйлэгдэж буйг үзүүллээ. “Нутгаа их зүүдэлж байна. Зурагтаар уул цэнхэртээд л, наана нь их тал цэлийсэн кино юм уу, нэвтрүүлэг гарангуут л нутагтаа нэг очихсон гээд огшоод явчихдаг юм. Сүүлд долоон жилийн өмнө очсон. Хөлөө гэмтээчихсэн байсан үе. Бөөнцагаан нуурынхаа бүлээн усанд ороод өвдгөөр татахуйц болонгуут таягаа орхичхоод цааш гүн рүү нь яваад өгсөн. Жигүүртэй болчихсон гэж ярьдаг шиг хөлтэй болчихсон юм шиг л сайхан санагдаж байсан даа” хэмээн ярьж байсан нь сонины хуудаст үлджээ. Баацагааны “банхар Пүүжээ” хэмээх нутаг амьтай сэтгэлийн гэрэлт найрагч байжээ.

Тэрбээр хань Б.Навчаатайгаа “Залуучуудын үнэн” сонинд танилцаж, таньж гал голомтоо бадраажээ. Тэд Заяа охин, Пүрэвжаргал хүүгийн ээж аав болов. Охин нь багшийн мэргэжил сонгож, хүү нь сэтгүүлч болсон нь монголын телевиз үзэгчдийн сайн танил ТВ-9 телевизийн “Монгол коммент” нэвтрүүлгийн хөтлөгч П.Пүрэвсүрэн билээ. Амьдрал, удам, уянга үргэлжилсээр. Уран бүтээлчийн гэргий уран бүтээлч буюу сэтгүүлч бүсгүй байсан нь П.Пүрэвсүрэнгийн утга уянга, шүлэг найраг, сод зохиолууд тасралтгүй онгодтой байхад тун их нөлөөлсөн болов уу. Яруу найрагч Пашка гуайд өгсөн амлалтаа үнэнчээр “Тогоруу, тогоруу, тогоруухай...” гэдэг дууг нь Б.Навчаа эгч бараг насан туршдаа “хундаганы ард” дуулсан байх шүү” гэж яруу найрагч Л.Өлзийтөгс тэдний тухай нэгэн дурсамждаа өгүүлжээ. Ийм үнэнч, тийм гэгээхэн, тэгээд бас шаггүй дууч бүсгүй, утга уянгын зохиолчийг хөглөн тэтгэж байж.

Цастай гудамж гантиг шиг цайж

Цацрах гэрлээр туяарч мишээхэд

Холын тэнгэрт одод инээн

Хонгор чи минь дэргэд ирнэ... П.Пүрэвсүрэн найрагчийн хань Б.Навчаадаа зориулж бичсэн цор ганц шүлэг.

Ирэх өдрүүдэд өвлийн тэсгим шаврыг уярааж хэдэн мянган удаа эгшиглэж, хүмүүст баяр баясал хайр түгээх уран бүтээл.

“Эхийн ач”, “Миний ээж тэмээчин” зэрэг монгол ахуй, монгол ээж, монгол хүн харагддаг түүний шүлгүүдээр бүтсэн дууг ардын дуу хэмээн дурдах нь цөөнгүй.

Гурван хоногтой улаан нярай хөгшин шар ингэ “унаж” ирсэн цагаас хойш Далан түрүүний гол, Бөөнцагаан нуурыг өгсөж уруудан тэмээчин ижийдээ үүрүүлж, дүүрүүлж өссөн хүн ардын дуу шиг үнэн ааруул шиг амттай байхаас ч яах билээ.

Өвсний толгой цайраад байна

Өвөл болохын шинж үү дээ

Өөрөө ч мэдэлгүй уйлах юм

Ижийгээ санасны шинж үү дээ...

Санаж бэтгэрсэн ижийдээ үнсүүлж, аавдаа хурдан золгохыг мөрөөсөж шалгалт шүүлгээ урьдчилж өгөөд товлосон хугацаанаас хоёр сарын өмнө алс холоос ирсэн 1985 он. “Нөгөөдөр ирнэ ээ” гэж амлаад гарсан ч тэр оройдoo түргэний эмчтэй уралдан ирсэн ч хайрт ижийгээ бурханд алдсан тухай П.Пүрэвсүрэн зохиолч ээжээ дурсан тэмдэглэхдээ халиран, хайлж бичсэнийг уншихад ч эмзэг хөндүүр ажээ. Хорвоогийн жамаар өнөөдөр тэр өөрөө ч тэнгэрийн зохиолч болоод арван жилийг үдэж байна. Гэхдээ энэрэнгүй, хүний сайхан нөхөр Баацагааны “банхар Пүүжээ”, түүний эх эцгийн элбэрэл, хүн байгалийн холбоо, жам, хайр энэрлийн тухай утга уянгын бүтээлүүд нь гэрэл түгээж оршсоор, үргэлжилсээр байх нь дамжиггүй.

**МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн 3 дугаар
дамжааны оюутан Б.Лувсанпэрэнлэй.**